

**ДЭЛХИЙН БАЙГАЛЬ ХАМГААЛАХ САН (WWF)-ГИЙН
МОНГОЛ ДАХЬ ХӨТӨЛБӨРИЙН ГАЗРЫН БАЙГАЛЬ
ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН
2023-2024 он**

АГУУЛГА

Өмнөх үг	4
Бидний тухай	6
Зүйлийн хамгаалал	8
Цоохор ирвэс	9
Монгол бөхөн	12
Цагаан зээр	14
Цэн тогоруу	16
Тул загас	18
Зэрлэг амьтныг аврах, асран хамгаалах	20
Зэрлэг амьтны хууль бус агнуур, худалдаа	24
Байгаль орчны мэргэжилтэн, байгаль хамгаалагчдын чадавх	28
Зэрлэг амьтдад ээлтэй шугаман дэд бүтэц	30
Экосистемийн нөхөн сэргээлт	34
Булаг усыг нөхөн сэргээх, хөв цөөрөм байгуулах	34
Ойн нөхөн сэргээлт	36
Хамгаалагдсан газар нутаг	38
Усан сан бүхий газрын хамгаалалтын бүс	39
Улсын тусгай хамгаалалттай газар нутаг	40
Орон нутгийн хамгаалалттай газар	44
Хилийн ногоон бүс	46
Газрын нэгдсэн менежмент	48
Газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөлт	48
Уур амьсгалд дасан зохицсон газар тариалан	50
Бэлчээрийн нэгдсэн менежмент	52
Нутгийн иргэд байгаль хамгаалалд	54
Мэдээлэл харилцаа	58
Засаглал, санхүүжилт	64
Байгаль орчин, нийгэм хамгаалал	68





© Б.Мөнхзориг / Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

ӨМНӨХ ҮГ



Д.Батболд

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын захирал

Байгаль бол олон сая жилийн турш бүрэлдэн бий болсон газар нутгийн тогтоц, амьтан, ургамал ба бусад эд юмс, зүйлсийн харилцан уялдаа холбоо бүхий цогц бүрэлдэхүүн юм. Хүн төрөлхтөн саяхныг болтол энэхүү байгалийн зүй тогтоц, цогц бүтцийг дарамт болохуйц байдлаар хөндөлгүйгээр зэрэгцэн оршсоор ирсэн билээ.

Нүүдлийн мал аж ахуй эрхлэгчид байгалийн уялдаа холбоо, эргэлтээс тодорхой хэмжээний ашиг шимийг малаараа дамжуулан хүртэх арга ухааныг таньж үр хойчдоо өвлүүлж ирсний ачаар өнөөдөр бид харьцангуй онгон зэрлэг байгальтай мөн цоохор ирвэс, Монгол бөхөн, цагаан зээртэйгээ зэрэгцэн амьдарч байгаа билээ. Гэвч сүүлийн хэдэн арван жилд уур амьсгалын тогтсон горим өөрчлөгдөж, малын тоо толгой нэмэгдэж, бодлогогүй бас мэдлэггүйн харгайгаар хүний байгальтай харьцах хандлага өөрчлөгдөхийн хэрээр бэлчээр нутаг, хөрс талхлагдаж, ой мод багасаж, булаг шанд ширгэж ирлээ.

Үүнд хүний буруутай үйл ажиллагаа жин дарж байгаа бөгөөд энэ нь бид бүхнийг байгаль дэлхийгээ онцгойлон хамгаалах зайлшгүй шаардлагын өмнө авчраад байна.

Таны сонирхон үзэж байгаа энэхүү бичиг бол Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын зүгээс сүүлийн 2 жилд (2023-2024 он) дээр дурдсан сөрөг нөлөөллүүдийг бууруулахын тулд хийж хэрэгжүүлсэн хамгааллын үйл ажиллагааны товч тайлан бөгөөд үүнийг уншигч танаа өргөн барьж байгаадаа баяртай байна.

Энэхүү тайланд манай байгууллагын Байгаль хамгаалах стратегийн хүрээнд хамгаалах, тодорхой арга хэмжээ авах шаардлагатай хэмээн тодорхойлсон цоохор ирвэс, Монгол бөхөн зэрэг зарим зүйлийн нэн ховор болон ховор амьтан, тэдгээрт болон тэдний амьдрах орчинд учирч байгаа аюул заналыг бууруулах, арилгах, Говь нутгийн чандмань эрдэнэ болсон булаг усыг сэргээх, хамгаалах, мөн Монгол орны нийт нутгийн гол мөрөн усан сан бүхий газрыг хамгаалах, түүнчлэн хамгаалал бүхий газар нутгийг өргөтгөх, менежментийг сайжруулах чиглэлээр бидний хийж хэрэгжүүлсэн ажлын талаар дурьдсан болно.

Үүнээс гадна байгалийн нэгэнт бүрэлдэн бий болсон зүй тогтоцыг хадгалах, биологийн олон янз байдлын хэрэгцээ шаардлагыг газар зохион байгуулалтын хэрэгцээ шаардлагатай хамтад нь тооцсон нэгдсэн төлөвлөлтийг зарим тодорхой газар нутгийн тухайд боловсруулах ажлыг санаачлан хэрхэн хэрэгжүүлсэн тухай дурьдсан болно.

Мөн нутгийн иргэдийн оролцоотой мод бут тарьж ургуулах, арчлах санаачлагыг хамтран хэрэгжүүлж байгаа нь “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд тодорхой хэмжээний хувь нэмэр болж байгаа гэж найдаж байна.

Дэлхийн хэмжээнд уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшигт үзэгдлийн давтамж 1970 онтой харьцуулахад 5 дахин нэмэгдсэн байна. Уур амьсгалын энэхүү өөрчлөлтөд нэн эмзэг 10 орны нэгээр Монгол улсыг нэрлэсэн байдаг төдийгүй өндөр уулын экосистем буюу цоохор ирвэсийн нутаг уур амьсгалын өөрчлөлтөд нэн өртөмтгий болохыг эрдэмтэн, судлаачид тогтоожээ. Жишээлбэл мөнх цас, мөсөн голын багасах явдал 1990 оноос эрчимжиж даруй 14%-иар буурсан бөгөөд сүүлийн 10 жилд энэ үзэгдэл улам бүр эрчимжиж байгааг эрдэмтэн судлаачид хэлж байна. Түүнчлэн Алтай-Соёны бүс нутагт мөнх цэвдгийн хомсдол бий болох, гол мөрний мөс хайлах үйл явц эрт эхлэх, мөсөн бүрхүүлийн зузаан багасах зэрэг үзэгдэл ажиглагдахаас гадна орон нутгийн шинж чанартай бичил цаг уурын одоогийн болон болзошгүй олон сөрөг нөлөөлөл ажиглагдаж байна. Бүс нутгийн өвөрмөц биологийн онцлог, бүрэн бүтэн байдлыг хадгалахын тулд эдгээр аюул занал, тэдгээрийн үндсэн шалтгааныг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Байгаль хамгаалах чиглэлээр бидний хийж хэрэгжүүлж байгаа бүхий л ажлын үндсэн зарчим бол байгалийн зүй тогтолд суурилсан, хүн төвтэй байгаль хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх явдал бөгөөд үүнд талуудын ялангуяа орон нутгийн иргэдийн оролцоо өндөр байх шаардлагатай. Орон нутгийн иргэд өөрсдөө байгалийн баялгийнхаа талаар үнэн бодит, шинжлэх ухаанд суурилсан мэдлэг, мэдээлэлтэй байх, үүнд суурилсан шийдвэр гаргаж чаддаг байх, ирээдүй хойч үеийнхний маань сайн сайхан амьдралын үндсэн эх сурвалж нь байгаль юм гэдгийг ойлгуулах явдал бидний бас нэгэн хүсэл бөгөөд үүнд хүрэхийн тулд бид орон нутгийн иргэдтэй хамтран ажиллаж, тэдний дэмжлэгийг авч мөн тэдэндээ тусалж дэмжин хамтран ажилласан тухай та энэхүү тайлангаас унших болно.

Бидний хийж хэрэгжүүлсэн ажлын талаар мэдлэг мэдээлэл авч бидэнтэй хамтран ажилласан танд баярлалаа.

БИДНИЙ ТУХАЙ

© Б.Гантулга / Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар



Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар Монгол Улсад анх 1992 онд байгаль хамгааллын төслийг хэрэгжүүлж эхэлснээс хойш даруй 32 жилийг ардаа үджээ. Энэ хугацаанд тус хөтөлбөрийн газар нь дэлхийн хэмжээнд зайлшгүй хамгаалах шаардлагатай гэж тодорхойлсон Алтай-Соёны экобүс болон Амар мөрний сав газарт байгаль хамгааллын ажлыг тасралтгүй, амжилттай хэрэгжүүлж иржээ. Манай байгууллагын тавдугаар таван жилийн байгаль хамгааллын хөтөлбөр (2021-2025)-ийн хамгааллын үнэт зүйлд цэнгэг ус, сэрүүн бүсийн ой, тал хээрийн экосистем, тал хээрийн туруутны нүүдэл, нүүдлийн зүйл шувуудын нүүдэл, цоохор ирвэс, монгол бөхөн зэрэг экосистем, экологийн процесс, нэн ховор амьтад багтдаг. Эдгээр хамгааллын үнэт зүйлээр дамжуулан нутгийн иргэд, талуудын оролцоонд түшиглэсэн хүн төвтэй байгаль хамгааллын зарчмыг авч хэрэгжүүлснээр экосистемийн үйлчилгээг хэвийн хадгалах, хүн байгалийн зэрэгцэн орших нөхцөлийг бүрдүүлэх нь бидний тэргүүлэх чиглэл болно. Түүнчлэн дахин давтагдашгүй байгаль, экологийн үйл явц, нэн ховор амьтдыг ирээдүй хойч үедээ өвлүүлэн үлдээх чин эрмэлзлээр тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөх, менежментийн чадавхыг сайжруулах, нийгмийн нийтлэг хандлагыг байгаль орчинд эерэг болгох, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон дадлыг нутагшуулах, байгаль хамгаалал, байгалийн нөөцийн тогтвортой ашиглалтыг дэмжсэн мэдлэг, мэдээлэлийг түгээн дэлгэрүүлэх чиглэлийг баримтлан ажилладаг.



Анх хоёр ажилтантай үйл ажиллагаагаа эхлүүлж байсан тус хөтөлбөрийн газар өдгөө 50 гаруй мэргэжилтнээс бүрдсэн чадварлаг баг Улаанбаатар хот дахь төв байгууллага, Ховд аймгийн төв, Хэнтий аймгийн Дадал суманд тус бүр салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна.



Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Зам, тээврийн яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Монгол улсын Их сургууль, шинжлэх ухааны байгууллага, төрийн бус байгууллага, олон улсын төсөл, орон нутгийн төр захиргааны байгууллага, хууль хяналтын байгууллага, хувийн хэвшил, орон нутгийн иргэд, сурагчдын эко-клубын гишүүд нь байгаль хамгааллын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд хамтран ажилладаг гол түншлэгчид юм.

ЗҮЙЛИЙН ХАМГААЛАЛ



ЦООХОР ИРВЭС

953



Монгол орны хэмжээнд нийт нутаг дэвсгэрийн 21 хувь буюу 328,000 км² нутаг дэвсгэрт дундажаар 953 бие гүйцсэн цоохор ирвэс тархсан байна.

1059



Малчин өрх, малын тоо өсөхийн хэрээр өндөр уулын бэлчээрт цоохор ирвэс зэрэг махчин амьтдын эзэмшил нутаг руу мал түрэн орсноор амьдрах орчны хомсдол үүсэх, бэлчээр доройтох, ирвэс, хүн хоорондын зөрчил нэмэгдэх хандлагатай байна. 2023 онд ирвэсийн гол байршил 9 томоохон уулын хэмжээнд 1059 мал ирвэсэнд бариулсны 175 нь шөнө өвөлжөөнөөс, 884 нь өдрийн цагаар бэлчээрт тохиолджээ.

1270 км



Цоохор ирвэсийн тархац байршил нутгаар 1270 км урттай улсын болон орон нутгийн чанартай 20 авто зам, 478 км урттай 3 төмөр зам дайран өнгөрөх (төлөвлөж буй төмөр зам) бөгөөд нийт 38 цэгт авто болон төмөр зам ирвэсийн тархац нутгаар дайран өнгөрч байгаа нь шугаман дэд бүтцийг байгальд ээлтэй, төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Цоохор ирвэс хамгааллаар 2023-2024 онд гарсан амжилт, сургамж



Автомат камерийн судалгаанд 6 ууланд 19,199 км² талбайд 500 камерыг байршуулан судалгаа хийж байна.

44



44 малчин сайн дурын байгаль хамгаалагчаар ажиллаж байгаагийн олонх нь гурваас дээш жил уулсаа хамгаалж, нутаг усныхандаа байгаль хамгааллын талаар мэдээ мэдээлэл хүргэн ажиллаж байна. Тэд ирвэсийн амьдрах орчны эргүүл, хяналтад жилдээ 3-5 удаа, судалгаанд 3-4 удаа оролцож ирвэсээр дамжуулан байгаль орчны өргөн мэдлэг эзэмшиж байна.

173,000



Ирвэс тархсан Хархираа-Түргэн, Сайр-Хатуу, Дарви, Хасагтхайрхан уулсын хэмжээнд идэш болгоч зүйл болох Монгол тарваганы тоо толгой 173,000 орчим байгаа нь 2020 оны судалгааны дүнтэй харьцуулахад 9%-иар өссөн байна.



© Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар



“Хоточ банхар” хөтөлбөр үргэлжилж Дарвийн нурууны 42 өрх 60 гаруй банхраар хотоо мануулж махчин амьтдын халдлага 74 хувиар буурчээ. Түүнчлэн банхрын гөлгийг хэрхэн өсгөх, хонь хариулж, хоточ болгох талаарх сургалтыг 42 өрхийн хэмжээнд зохион байгуулсан нь үр дүнтэй боллоо.



2023 онд хууль бусаар ирвэс агнасан 1 гэмт хэрэг гарч байсан бол 2024 онд бүртгэгдээгүй.



© Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар



МОНГОЛ БӨХӨН



Монгол бөхөн идэш тэжээл, усны хүртээмжийг дагаж сэлгэн нүүдэллэдэг туурайтан амьтан. Хамгааллын ажлын хүрээнд тоо толгой нь сүүлийн жилүүдэд өсөж, тархац нутаг нь 1930 оны түвшинд хүрч 46,000 км² болжээ. Бөхөнгийн сүрэгт уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй ган, зуд, мал бэлчээрлэлтээс улбаатай бэлчээр, усны хомсдол, одоогийн болон төлөвлөгдсөн шугаман дэд бүтцээс үүдэлтэй тархац нутгийн хуваагдал болон халдварт өвчин заналхийлсээр байна.



Монгол бөхөн 1930-аад оны үед тархаж байсан түүхэн тархац нутаг болох Увс аймгийн Завхан, Наранбулаг сумдын нутагтаа 90 жилийн дараа эргэн ирж 2023 онд 464 бодгаль, 2024 онд 763 бодгаль болж өсөн нэмэгджээ.



© Б.Мөнхзориг / Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

Монгол бөхөн хамгааллаар 2023-2024 онд гарсан амжилт, сургамж



Монгол бөхөнгийн тоо толгой мөхлийн ирмэгт ирсэн 2003 онтой харьцуулахад 2023 онд багадаа 15,540 бодгаль тоологдсон буюу 20 дахин нэмэгджээ.

14



46,000 км² га газар нутгийг 14 малчин, нутгийн иргэдээс бүрдсэн “Бөхөн хамгаалах сүлжээ” баг бүхэлд нь хянаж, бөхөнгийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг цуглуулж, бөхөн хамгаалах, мэдээлэл түгээх ажлыг хийсээр байна.

67



Тархац нутгийн хэмжээнд 67 булгийн 31,9 га газар нутгийг сэргээн, экосистемийн бүрэн бүтэн байдлыг тэтгэх ажил хийлээ.



Хууль бусаар агнасан, эврийг худалдаалсан гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.



ЦАГААН ЗЭЭР

472



Монгол орны цагаан зээрийн популяцийн тоо толгойг шинэчлэн тогтоох судалгааг 2024 онд хийв. Судалгаагаар 472 сүргийн 126,847 бодгаль тоологдсон бөгөөд Монгол орны хэмжээнд дунджаар 1,5 сая цагаан зээртэй гэсэн үнэлгээг судлаачид гаргасан байна. Энэ нь 2020 оны судалгааны дүнтэй харьцуулахад 500 орчим мянган бодгалиар цөөн байна. Мөн цагаан зээрийн сэг зэмийн судалгааг давхар хийж 756 сэг зэм тэмдэглэсэн бөгөөд Дорнод аймгийн Халхгол, Матад сумуудад сэг, зэм хамгийн их бүртгэгдсэн байна.



20



2023-2024 оны өвөл тохиосон зудны улмаас зэрлэг амьтад тэр дундаа цагаан зээр ихээр хорогдсон. Тухайлбал, зүүн бүсэд хүзүүвч зүүсэн 25 цагаан зээрийн 20 нь 2023 оны зуднаар хорогдсон.

35



Зүүн бүсэд цагаан зээрийн тархац нутгийн хэмжээнд нийт 6,260 км урттай 157 холбоос нутгийг зураглаж Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд цагаан зээрийн шилжих холбоос нутаг, төллөх чухал орчныг харгалзан үзэж тус аймгуудын нутгаар дамжин өнгөрөх улсын болон орон нутгийн чанартай авто зам, төмөр замын дагуух нийт 35 байршил (авто замд 26, төмөр замд 9)-д зэрлэг амьтны гарц, гарам байгуулах шаардлагатай болохыг тогтоон төлөвлөлт хийсэн.

ЦЭН ТОГОРУУ

77.2%



2022 оны 7 дугаар сард Онон, Хэрлэн голын сав газарт хийсэн судалгааны дүнгээс үзэхэд үржлийн 22 хос бүртгэгдсэн бөгөөд үржлийн хувь 77.2% байна. Ихэнх хосууд зөвхөн нэг дэгдээхэй өсгөсөн бөгөөд өмнөх жил нь дэгдээхэй гаргасан 7 хос дахин үржээгүй. Цэн тогорууны популяцид хуурайшилтаас үүдэлтэй намгархаг орчны хаталт, үүрлэх орчинд мал бэлчээрлэлт нэмэгдэх зэрэг сөрөг нөлөө ажиглагдаж байна.

2984 км



Улз, Хэрлэн голын дагуу цэн тогоруу өндөглөж зусдаг чухал нутгуудыг тогтоох зорилгоор долоон дэгдээхэйд дамжуулагч зүүж 2023 оны 7-р сарын 26-наас 11-р сарын 17-нд 4266 байршлын цэг бүртгэсэн. “Булган” нэртэй дэгдээхэй 10 дугаар сарын 19-ний өдөр Хэрлэн голын хөвөөн дэх төрсөн нутгаасаа хөдөлж 2984 км агаарын замыг туулж 11-р сарын 13-ны өдөр Хятадын Гуюань мужид хүрч өвөлжжээ.

2.7 га



Цэн тогорууны үржлийн хосуудын үүрлэлт, үржлийн амжилтыг дэмжих, үржлийн бус хосуудад үүрлэх орчинг бүрдүүлэх, чухал амьдрах орчинг хамгаалах зорилгоор 2024 онд Хэнтий аймгийн Норовлин сумтай ойр орших Хулст нуурын 600 м урттай 2.7 га газрыг хашиж хамгаалав.

30



“Миний нутгийн дэгдээхэй” санаачилга өргөжсөөр 2024 онд 6 нуурын эргэн тойронд амьдардаг 35 хүүхдийг хамраад байна. Шувуудын үүрлэх орчинд малын бэлчээрийн давхцал үүсэж, амьдрах орчныг доройтуулах, бохирдуулах, улмаар үржлийн шувууд үүрлэхгүй байх, үржил амжилтгүй болох, өндөг, дэгдээхэй эндэх зэрэг аюул дарамт тулгарч байгаа тул хүүхдүүд нутгийн иргэдэд энэ талын зөв ойлголт, мэдээлэл өгч байна. Үүний үр дүнд шувуудын үржлийн бүсэд ойрхон нутагладаг 30 гаруй малчин үржлийн үеэр нохойгоо уях, мал бэлчээрлэлтийг хязгаарлаж хамтран ажиллаж байгаа ба хүүхдүүд ч тогтмол хяналт тавьж байна.



© М.Ууганбаяр / Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

ТУЛ ЗАГАС

1,6



Онон-Балж гол, түүний загас агнуурын бүс нутагт 2023 онд хийсэн ердийн тул загасны нөөцийн судалгаагаар нас бие гүйцсэн (>66 см) тул загас 1 км-т 8.7 бодгаль оногдож байна. 2016 оны судалгаагаар Онон голд 1 км-т 1,6 тул тоологдож байв.

70



2024 оны байдлаар нутгийн иргэдийн 70 гишүүнчлэлтэй Онон голын загас хамгаалах клуб 168,703,49 га газрыг хариуцан хамгаалж байна.

440



Онон голын загас хамгаалах клуб 2024 онд Онон-Балжийн байгалийн цогцолбор газрын хамгаалалтын захиргаатай хамтран тул загасны өдөрлөгийг Онон голын сав газрын 6 суманд зохион байгууллаа. Өдөрлөгийн үеэр 310 иргэн, 440 гаруй сурагчид тул загасны үнэ цэн, ач холбогдлын талаар мэдээлэл түгээсэн.



© С.Пурзвдорж / Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

ЗЭРЛЭГ АМЬТНЫГ АВРАХ, АСРАН ХАМГААЛАХ



Өвчилсөн, гэмтэж бэртсэн амьтанд тусламж үзүүлэх, авран хамгаалах нь хамгааллын нэг хэлбэр болох тухай үзэл санааг Амьтны тухай хуульд тусгахад Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар идэвхтэй ажилласан билээ.



Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах үйл ажиллагаатай холбоотой цогц 4 стандартыг 2022 онд батлуулж чадсан нь зэрлэг амьтан хамгаалалд томоохон амжилт болсон билээ. 2023-2024 оны байдлаар Алтай-Соёны бүс нутагт нутгийн иргэдийн 7 дуудлага, мэдээлэл ирсэн бөгөөд Зэрлэг амьтан аврах, асран хамгаалах багийнхан (Байгаль орчны газар, Мал эмнэлгийн газар, Цагдаагийн газар) хамтран ажиллаж зэрлэг амьтдыг аврав *(дэлгэрэнгүйг дараагийн хуудаснаас үзнэ үү)*.





© Б.Гангулга / Дрлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар



Увс аймагт нисэж чадахгүй жороо тоодог шувууг барьж анхны тусламж үйлчилгээ үзүүлэн байр оромж бэлтгэж, тэжээн тордож өвөлжүүлэн байгальд нь эргүүлэн тавьжээ.



Аргаль эргүү өвчин туссан байгаа тухай мэдээлсний дагуу тус аймгийн амьтан авран хамгаалах баг газар дээр нь ажиллаж, анхны тусламж үзүүлж, 4 хоног тэжээн тордож байгаад ижил сүрэгт нь нийлүүлсэн байна.



Баян-Өлгий аймгийн Ачит нуурын мөсөнд боогдсон нэг сая гаруй Алтайн османы (*Oreoleuciscus potanini*) жараахайг 40 гаруй байгаль хамгаалагчид, Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн мэргэжилтнүүд хамтран 20 цагийн дотор 8 км зайтай гол руу шилжүүлэн аварч чаджээ.





Говь-Алтай аймагт нас бие гүйцсэн угалз толгойгоо даахгүй байна гэсэн дуудлагаар газар дээр нь очиж, анхны тусламж үйлчилгээ үзүүлсэн бол малчин айлын хотонд ирсэн нэн ховор нүүдлийн шувуу болох хонин тоодгийг аварч, арчлан тордож байгальд нь тавьжээ.



Мөнххайрханы байгалийн цогцолборт газрын нутагт хойд хөл нь гэмтсэн цоохор ирвэс байна гэсэн дуудлага ирсэн. Ирвэсийн баруун хойд хөлний гуяны арьс урагдаж, өт цацсан байв. Шархадсан ирвэсэнд анхан шатны тусламж хүргэж, байгальд нь буцаав.



Гэрийн мал дагаж ирсэн хар сүүлт зээрийн янзагыг тусгай хашаанд 4 хоног байршуулан арчлан тордож байгаад байгальд нь эргүүлэн тавьжээ.



Байгаль хамгаалагчид нуурын мөсөнд боогдсон жараахайг аварч байгаа нь

ЗЭРЛЭГ АМЬТНЫ ХУУЛЬ БУС АГНУУР, ХУДАЛДАА

Биологийн олон янз байдлын хууль бус агнуур, худалдааны зөрчлийн илрүүлэлтийг нэмэгдүүлэх, энэ төрлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба болон Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөл, аймгуудын ИТХ-ын ажлын алба, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Улсын ерөнхий прокурорын газар, Олон улсын Улаанбаатарын их сургууль зэрэг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаа.



2023 оны 4-5 дугаар сард “Хууль бусаар ан агнах, ой, байгалийн ургамал бэлтгэх, худалдаалах гэмт хэрэг, зөрчлийг мөрдөн шалгах, шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт сургалтыг аймгуудын прокурор, цагдаа, хил, гааль болон байгаль орчны байгууллагуудын 120 гаруй албан хаагчдын оролцоотойгоор зохион байгууллаа.

Сургалтыг ойлгомжтой, сонирхолтой болгох үүднээс тухайн сэдвийн хичээлүүдээ бодит хэрэг, зөрчлийн жишээ, баримт дээр тулгуурлан тайлбарлаж, багаар ажиллуулж, харилцан ярилцах, хэлэлцүүлэг өрнүүлэх зэрэг хэлбэрийг сонгосон нь илүү үр дүнтэй, өгөөжтэй болов.



“Цагаан зээрийн хууль бус агнуурыг бууруулах боломж” уулзалтыг Дорнод аймгийн Чойбалсан хотод 2023 оны 6 дугаар сард Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Дорнод аймгийн ИТХ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, ЦЕГ-ын Экологийн цагдаагийн газруудтай хамтран зохион байгууллаа. Тус уулзалтад зүүн 3 аймгуудын Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн гишүүн байгууллагуудын нийт 40 гаруй албан тушаалтнууд оролцож цаашид жил бүр тусгайлан хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө баталж, хэрэгжүүлэхээр боллоо.



© Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар



70 “Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг ба прокурорын хяналт” сургалтыг 2023, 2024 онд зохион байгуулсан бөгөөд сургалтад Монгол Улсын 21 аймаг, нийслэл дэх Прокурорын газруудын 70 гаруй прокурор хамрагдав. Тус сургалтыг Улсын ерөнхий прокурорын газар, Монголын хуульчдын холбоо, Монгол Улсын Их Сургууль, Дотоод хэргийн их сургуулийн эрдэмтэн судлаач, багш нар удирдан явуулав.



142 Нэн ховор, ховор амьтан, ургамлын тархац, нөөц, биологи, экологийн онцлог, зэрлэг амьтны эд эрхтнийг ялган таньж тодорхойлох мэдлэг, ур чадвар олгох сургалтад 142 алба хаагчдыг хамрууллаа.



128

Зэрлэг амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн хил дамнасан хууль бус худалдаанаас урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр 2017 оноос хойш 2 жилийн давтамжтайгаар 4 дэх удаагийн сургалтыг 2024 онд “Зэрлэг амьтан, тэдгээрийн гаралтай эд зүйлийн хил дамнасан хууль бус худалдаанаас урьдчилан сэргийлэх, хуулийн хэрэгжилтийг хангах нь” сэдвээр зохион байгуулж, баруун бүсийн 5 хилийн боомтод үүрэг гүйцэтгэж байгаа хилийн хяналтын байгууллагуудын нийт 128 алба хаагчдыг хамруулав. Сургалтаар Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES), түүний хавсралтад орсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлсийн бичиг баримтын бүрдүүлэлт, шалгахад анхаарах зүйлс болон Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хуулийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал, энэ төрлийн хэрэг зөрчил, илрүүлэлтийн сайн туршлагын талаар мэдээлэл өгөв.




Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар талуудтай хамтран Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES), зэрлэг амьтдын хууль бус худалдааны талаарх Лондон болон Касанегийн бага хурлын тунхаг, протокол, түүнчлэн Монгол Улсын Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг цогцоор нь хамруулсан нөлөөллийн шинжилгээг 2017, 2021 онд хийсэн. Энэ хүрээнд нийт таван хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал, мөн дөрвөн журмын төслүүдийг боловсруулж, Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд хүлээлгэж өгсөн. Үүний үр дүнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн А/240 дүгээр тушаалаар Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц (CITES)-ыг хэрэгжүүлэх Үндэсний Удирдан зохицуулах зөвлөл болон Шинжлэх ухааны зөвлөлийн ажиллах журмууд батлагдлаа.



34

Цагдаагийн ерөнхий газрын Экологийн цагдаагийн алба, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албатай хамтран 2024 онд 3 багц 34 цуврал хичээлийг видео хэлбэрээр бэлтгэж, Цагдаагийн ерөнхий газар, Экологийн цагдаагийн албаны цахим хуудас дахь албан хаагчдад зориулсан дотоод сүлжээний сургалтын хэсэгт байршуулсан бөгөөд төв болон орон нутгийн экологийн асуудал хариуцсан албан хаагчид судалж, сургалтын материал болгон ашиглаж байна.





© Б.Цэндцэцэн / Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол Дөхь хөтөлбөрийн газар

БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН, БАЙГАЛЬ ХАМГААЛАГЧДЫН ЧАДАВХ



Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн дахь хөтөлбөрийн газрын санаачилга, хамтын ажиллагааны хүрээнд SMART системийг 2018 оноос эхлэн Монгол улсын зарим ТХГН-т нэвтрүүлсэн.


Энэ ажлын хүрээнд Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам SMART программыг нэгдсэн удирдлагаар хангаж, үндсэн сервер үүсгэж нэгдсэн мэдээллийн сан бий болгохоор ажиллаж байгаагаас гадна, сайдын 2023 оны 6 дугаар сарын А/219 дүгээр тушаалаар улсын тусгай хамгаалалттай газар нутагт хяналт, шалгалтын ажлыг зохион байгуулахад ашиглагдах тус программын гарын авлагын арга зүйг батлуулж, улмаар улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын бүх хамгаалалтын захиргаадын мэргэжилтэн, байгаль хамгаалагч нарыг хамруулан бүсчилсэн хэлбэрээр сургалтыг зохион байгуулж, нэвтрүүлэхээр болов.



Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулах ажлыг сүүлийн 5 жилийн хугацаанд талуудтай хамтран хэрэгжүүллээ. Үүний үр дүнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/189 дүгээр тушаалаар “Байгаль хамгаалагчийг мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр” батлагдсан. Ингэснээр улсын байцаагчийн эрхтэй байгаль хамгаалагч, байгаль хамгаалагч, туслах байгаль хамгаалагч болон идэвхтэн байгаль хамгаалагч нарыг тодорхой үе шаттай, богино хугацааны системтэй хөтөлбөрөөр тэдний албан тушаалын тодорхойлолтод заагдсан чиг үүргийг гүйцэтгэхтэй холбоотой практик мэдлэг, ур чадварыг сайжруулж, чадавхжуулах боломж бүрдэж байгаа юм.



2024 оны эцсийн байдлаар бид улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын 21 хамгаалалтын захиргаадын 209 мэргэжилтэн, байгаль хамгаалагч нарт SMART программын шаталсан сургалтыг зохион байгууллаа.





© Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

ЗЭРЛЭГ АМЬТДАД ЭЭЛТЭЙ ШУГАМАН ДЭД БҮТЭЦ




12



Алтай-Соён, Амар мөрний бүс нутагт төлөвлөгдсөн шугаман дэд бүтэц (хатуу хучилттай зам, төмөр зам, цахилгааны шугам) ихэсч амьтдын амьдрах орчин хуваагдахаар байгаа тул аргаль, ирвэс, монгол бөхөн, хар сүүлт, цагаан зээр, мазаалай, хавтгай, хулан зэрэг 12 том хөхтөн амьтдын олон жилийн судалгаа мониторингийн өгөгдөл дээр үндэслэн, олон улсад хүлээн зөвшөөрөгддөг арга зүйгээр тухайн амьтдын тархац нутаг, холбоос нутгуудыг тодорхойлж тэдгээр нь шугаман дэд бүтцийн улмаас хуваагдах, нүүдлийн зам тасрах, нүүдлийн шувууд үдлэн дайрдаг газрууд өртөх байршлуудыг зураглаж мэдээллийн сан бүрдүүлсэн. Түүнчлэн шугаман дэд бүтцийн нөлөөг багасгах тодорхой зөвлөмжүүдийг боловсруулсан нь шинэ шугаман дэд бүтцүүд зэрлэг амьтдад сөрөг нөлөө багатай байгуулагдах, амьтдад ээлтэй шугаман дэд бүтцийг хөгжүүлэх стандартуудыг мөрдөх, нэгэнт бий болсон ээлгүй бүтцүүдийг солих, сайжруулах шинжлэх ухааны үндэслэл болж байна.



© М.Ууганбаяр / Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар



2023 онд ЗТХЯ болон БОУАӨЯ-тай хамтран зэрлэг амьтдад сөрөг нөлөө багатай хориг хашааны үндэсний стандарт боловсруулах шат дараатай ажлыг эхлүүлж “Төмөр зам болон хурдны авто замын хориг хашаа. Ерөнхий шаардлага MNS 7042: 2024” стандартыг боловсруулан Стандарт, хэмжилзүйн газраар 2024 оны 5 сарын 24-нд батлуулж мөн оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс мөрдөж эхэлсэн. Төмөр зам, хурдны замын хориг хашааг өргөст торгүй хийх, зэрлэг амьтад доогуур нь шургах, дээгүүр нь харайх зэргээр чөлөөтэй нэвтэрч байх шаардлагуудыг энэхүү стандартад тусгасан юм.

427 км



Тавантолгой-Шивээ хүрэн чиглэлд барихаар төлөвлөж байгаа 427 км төмөр зам дагуу зэрлэг амьтдад зориулсан 47 гарц, гарамыг байгуулах, Алтай-Цагаанхайрхан 40 км, Улиастай-Алтай 178 км, Улаангом-Ховд 163.3 км авто замуудын дагуу зэрлэг амьтдад зориулсан 31 гарц, гарамыг байгуулах зөвлөмжүүдийг амьтдын тархац нутаг, холбоос нутгуудыг тодорхойлсон судалгааны үр дүнд үндэслэн боловсруулж, Тавантолгой төмөр зам ХХК болон бусад холбогдох төслийн нэгжүүдэд хүргүүлсэн.



Шугаман дэд бүтцийг зэрлэг амьтдад ээлтэй бүтээн байгуулах үндсэн ойлголт олгох 5 модуль бүхий сургалтын хөтөлбөрийг боловсруулж шугаман дэд бүтцийн чиглэлээр шийдвэр гаргагч 8 төрийн байгууллага, 1 бүтээн байгуулах компани, үйл ажиллагааг нь хариуцан ажилладаг 2 төмөр замын байгууллага, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээ хийдэг 58 байгууллагын 221 шийдвэр гаргагч, ажилтнуудыг хамруулсан сургалтыг зохион байгуулав.



Шугаман дэд бүтцийн зэрлэг амьтдад үзүүлэх нөлөө, тэдгээрийг амьтдад ээлтэй төлөвлөх мэдлэг олгох зорилгоор Монгол Улсын Их Сургууль (МУИС)-ийн 10 хичээлийн хөтөлбөрт нийт 83 цагийн лекц болон семинараар сурах агуулгыг 2023 оны намар оруулсан. Дээрх агуулгыг оюутнууд судалснаар одоогоор баригдсан шугаман дэд бүтцүүд зэрлэг амьтдын нүүдэл, шилжилт, урт хугацааны мэнд үлдэлтэд хэрхэн нөлөөлж байгааг бодит жишээн дээр үзэж танилцах, зэрлэг амьтдын амьдрах орчин, холбоос нутгууд, шугаман дэд бүтцийн ирээдүйд үзүүлэх нөлөөллийг таамаглах арга, аргачлалд суралцах, шугаман дэд бүтцийг төлөвлөхөд зэрлэг амьтдад тэдгээрээс үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах талаар зохих мэдлэгийг авах боломжтой болох юм. Одоогийн байдлаар МУИС-ийн 570 оюутан 2023-2024 оны хичээлийн жилд дээрх мэдлэгүүдийг судалж олж авсан бөгөөд цаашид ч урт хугацаанд тогтмол хүргэх боломжийг бүрдүүлсэн болно.





© М.Ууганбаяр / Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

ЭКОСИСТЕМИЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

© Б.Гантулга / Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар



БУЛАГ УСЫГ НӨХӨН СЭРГЭЭХ, ХӨВ ЦӨӨРӨМ БАЙГУУЛАХ



Уур амьсгалын өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны үр дүнд байгаль дээрх олон булаг усны эх бохирдох, хатах, ширгэх аюулд өртөөд байна. Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн дэмжлэгтэйгээр булгийн эхийг орон нутгийн оролцоотойгоор хашиж хамгаалснаар булгийн ундарга сэргэж, урсац нь нэмэгдэх нөхцөл бүрдсэнээр мал, зэрлэг амьтны усан хангамж, хүртээмж сайжирч байна. 2024 оны байдлаар хашиж хамгаалсан булгийн эхүүдийг дурдвал:

- Бөхөнгийн тархац нутгийн 67 булаг
- Ирвэсийн тархац нутгийн 8 булаг, 11 цөөрөм
- Цагаан зээр болон тогорууны тархац нутгийн 9 булаг (ТХГН-т хамаарах Баянцагааны тал БНГ, Хар ямаат БНГ, Улз голын эх БНГ).



Булаг, уст цэгийг сэргээх, эхийг хашиж хамгаалах ажлын амжилт, сургамжид тулгуурлан “Тал хээр болон говийн бүсэд булаг хашиж, хамгаалах аймгийн стандарт”-ыг Говь-Алтай аймгийн Засаг даргын 2023 оны 2-р сарын 23-ны өдрийн тоот тушаалаар баталсан.



Хатаж ширгэсэн гол горхи, булаг шандын эхийг зэрлэг амьтан, малын хөлөөс чөлөөлснөөр урсац сайжирсан олон сайн туршлага байна.

- Монгол бөхөнгийн тархац нутагт 100 булгийг 4 жилийн дотор нөхөн сэргээснээр 1000 малчин өрхийн усан хангамж, 15000 толгой бөхөнгийн амьдрах орчныг сайжруулж, уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг сааруулахаар нутгийн иргэдтэй хамтран ажиллаж байна. 2024 оны байдлаар 67 булгийн 31,9 га газар бүхий булгийн эхийг 400 гаруй нутгийн иргэдийн оролцоотойгоор хашиж хамгаалан эзэнжүүлээд байна.
- Сайн дурын байгаль хамгаалагчид, малчидтай урт хугацаанд хамтран ажиллах явцад ус багатай ч бэлчээр сайтай нутгуудад хөв цөөрөм байгуулах нь цоохор ирвэстэй зэрэгцэн орших нэг шийдэл хэмээн үзэж Дарвийн нуруунд 10 өрхийн 8600 гаруй малыг ундлах чадамжтай 1 том цөөрөм, Жаргалантын нуруунд 10 жижиг цөөрөм байгуулсны үр дүнд ирвэсийн нутгийг мал бэлчээрлэлтээс тодорхой хэмжээнд чөлөөлж, мал болон ирвэс түүний идэш бологч амьтдын усан хангамж сайжирлаа.
- Цагаан зээрийн өлгий Баянцагааны талын Элэгний булгийн эхийг Хэрлэн голын сав газрын захиргаа, иргэдийн оролцоотой 2023 оны 7 сард хашиж хамгаалснаар урсац нь секундэд $6\text{м}^3/\text{сек}$ хүрч, 420 метр зайнд урсдаг болсон.

ОЙН НӨХӨН СЭРГЭЭЛТ

© Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

48.5 сая



Иргэний байгууллагууд ойн нөхөн сэргээлтэд идэвхтэй оролцож, орлогоо нэмэгдүүлэх боломжтойг харуулсан олон сайн туршлага бий боллоо. Тухайлбал, “Мод дагаж ус, ус дагаж амьдрал” аяны хүрээнд эхэлсэн Дадал сумын “Цагаан булаг” нөхөрлөлийн 5 га, Батширээт сумын “Эв Эе” нөхөрлөлийн 3 га нөхөн сэргээсэн ой улсын ойн санд албан ёсоор бүртгэгдэж, нөхөрлөлүүд 2024 онд хуулийн дагуу 48.5 сая, 29.1 сая төгрөгийн нөхөн олговор авсан нь орон нутгийн иргэд хийсэн ажлынхаа үр шимийг хүртсэн амжилт боллоо.

2.8 сая



Онон голын сав газрын 45 гишүүнтэй иргэний 6 байгууллага 2022 онд 10 кг, 2023 онд 13.5 кг, 2024 онд 6 кг нарсны үр тарьж 1-2 настай 2.8 сая суулгац бойжуулаад байгаа бөгөөд 3 настай суулгацаа зах зээлд нийлүүлэхээр ажиллаж байна.



120



Хэнтий аймгийн Дадал сумын сурагчдын мойл жимсийг үрээр үрслүүлэн тарих ажил үргэлжилж, 2024 оны 5-р сарын байдлаар 3000 орчим суулгац бэлтгэснээс 600 ширхгийг “Үндэсний мод тарих өдөр”-өөр 120 өрхөд хандивлажээ. Энэ санаачилга нь орон нутгийн иргэдийг мод тарих, амьдрах орчноо сайжруулахад ихээхэн урам зориг өгсөн юм.

11729



Иргэдийн жимсний мод тарих хүсэл сонирхол нэмэгдэж өрхүүд хашаанаасаа жимсээ хураан авч хүнсэндээ хэрэглэх, орлого олж эхэлсэн нь ойн баялгийг хамгаалахад чухал нөлөө үзүүлж байна. 2016 оноос эхлэн “Өрх бүр жимсний аж ахуйтай болцгооё” аяныг жил бүр амжилттай зохион байгуулснаар нийт 3 аймгийн 14 сумын 1356 өрхөд, 11729 ширхэг жимсний модны суулгац өгч ургуулж байна. Нэг өрх дундажаар жилд 3-30 кг жимс хураан авдаг төдийгүй суулгац бэлтгэн модны тоогоо нэмэгдүүлэхээс гадна зарж борлуулж орлого олдог байна.

100



Сүүлийн жилүүдэд бид татмын экосистемд анхаарч 2023 оны 10-р сард Онон, Хэрлэн голын сав газрын 5 сумын эко-клубийн 100 гаруй сурагчдад татмын экосистемийн ач холбогдол, хамгааллын талаар танхимын болон хээрийн сургалт зохион байгууллаа.

32



2024 оны 1 болон 4-р сард татмын ойн менежментийг сайжруулах онол, практикийн сургалтад Хэнтий, Дорнод аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын алба, Хэрлэн голын сав газрын захиргаа, орон нутгийн засаг захиргааны байгууллагын 32 төлөөлөгч оролцож Хэрлэн голын татмын ойг хамгаалах өдрийг хамтран тэмдэглэж татмын ойг хамтран хамгаалахаар шийдвэрлэлээ.

ХАМГААЛАГДСАН ГАЗАР НУТАГ



УСАН САН БҮХИЙ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН БҮС

Усны тухай хуулийн хүрээнд усны сан бүхий газрын хамгаалалтын бүсийг тогтоох, аймгийн ИТХ-аар батлуулах, ЗГХА Усны газраар дамжуулан усны хамгаалалтын бүсийг газрын нэгдсэн мэдээллийн санд <https://egazar.gov.mn> бүртгүүлэх ажлыг улсын хэмжээнд хийхэд Алтай-Соёны экобүс болон Амар мөрний сав газарт хамаарах аймгуудтай хамтран ажилласан. Энэ ажлын хүрээнд 2024 онд Сүхбаатар аймагт 428 мянган га газар нутаг, Хэнтий аймагт нэмэлтээр 220 га газар нутгийг усны сан бүхий газрын хамгаалалтын бүсээр шинэчлэн тогтоосон юм. Одоогийн байдлаар Алтай-Соёны эко бүс, Амар мөрний эхийн Монгол оронд хамаарах газар нутагт нийт 8.6 сая га газрыг усны сан бүхий газрын хамгаалалтын бүсээр тогтоогоод байна.

УЛСЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР НУТАГ



БИОСАН нь биологийн олон янз байдлын мониторинг судалгааны мэдээллийг нэгтгэдэг бүртгэлийн систем юм. Урт хугацааны судалгааны мэдээлэлд суурилсан дүн шинжилгээ нь оновчтой төлөвлөх, шийдвэр гаргахад чухал үүрэгтэй. Анх Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газраас 2008-2009 онд тусгай хамгаалалттай газар нутгуудад энэхүү бүртгэлийн системийг нэвтрүүлсэн байна. 2023 онд дахин шинэчилсэн бөгөөд энэ нь байгаль хамгаалагч, мэргэжилтнүүдийн ажлыг хөнгөвчилж, мониторинг судалгааны мэдээллийн чанарыг сайжруулснаараа онцлог юм. Биосангийн www.eic.mn вебсайт болон гар утасны аппликэйшнийг хөгжүүлж, 6 арга зүй дээр автомат камерын мониторинг судалгааг нэмснээр зэрлэг амьтны тоо толгой, шилжилт хөдөлгөөний нарийвчилсан мэдээлэл цуглуулах боломжтой боллоо. Ингэснээр байгаль хамгаалагч ажлын талбараасаа судалгааны бодит мэдээллийг гар утсаараа дамжуулан илгээх, байгаль хамгаалагчийн аюулгүй байдлыг хянах, хаана явж байгааг мэдэх, мэдээлэх нөхцөл бүрдсэн юм.



Мөн байгаль хамгаалагчид, судалгааны мэргэжилтнүүдийг сургалтад хамруулж интернэт сүлжээгүй нөхцөлд ч гар утасны аппликейшн ашиглан судалгааны талбараасаа төв сервэрт мэдээлэл илгээж өмнө цаасаар өгдөг байсан тайлан мэдээг нэгтгэн боловсруулах боломжтой болов. Энэхүү вебсайт, гар утасны аппликейшнд урт хугацааны мониторинг судалгаа хийхэд түгээмэл ашигладаг олон улсад хүлээн зөвшөөрсөн, тухайн газрын онцлогт тааруулсан, хялбаршуулсан 7 төрлийн үндсэн арга зүйг тайлбарлан оруулсан. Үүний дагуу анхан шатны мэдээлэл цуглуулахад тавигдах шаардлага, дээж талбайн сонголт хийхэд анхаарах зүйлс, мэдээлэл цуглуулах хүснэгтэд өгөгдсөн үзүүлэлтүүдийг үнэн зөв бөглөх заавар зэргийг энгийн ойлгомжтой байдлаар багтааж өгсөн. Шинэчилсэн БИОСАН цахим мэдээллийн сангийн веб сайтыг Байгаль орчин, уур амьсгалийн яаманд 2023 онд хүлээлгэн өгсөн.





Хар-Ус нуурын байгалийн цогцолборт газар болон Онон-Балжийн байгалийн цогцолборт газрыг ЮНЕСКО-гийн Шим мандлын нөөц газруудын дэлхийн сүлжээнд бүртгэлээ. Ингэснээр уг ТХГН-уудын олон улс дахь ач холбогдол нэмэгдэж, хамгаалалт сайжрах, хамгаалахад шаардагдах хөрөнгө босгох боломж нэмэгдэх юм.



2024 оны байдлаар SMART программыг 21 тусгай хамгаалалттай газрын 13,067,489 га талбайд ашиглаж байна.



Дэ Нейче Консерванси байгууллагатай хамтран “Өвлөгдөн үлдэх газар нутаг-Онон-Балжийн байгалийн цогцолборт газар” төслийг хэрэгжүүлж эхлээд байна. 15 жилийн хугацаанд хэрэгжүүлэх энэхүү төслийн хүрээнд Онон-Балжийн Байгалийн цогцолборт газар, түүний орчны бүс нутагт хамрах сумд, бэлчээр, байгалийн нөөцийн менежментийн үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлж биологийн олон янз байдал, экосистемийн тогтвортой байдлыг хангах, нутгийн иргэдийн байгаль хамгааллын үйл ажиллагааг дэмжих, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг нэмэгдүүлэх, амьжиргаа болон байгальд ээлтэй орон нутгийн эдийн засгийг дэмжсэн загвар тусгай хамгаалалттай газрыг бий болгохоор зорин ажиллах юм.



Хар ямаатын Байгалийн нөөц газарт хууль бус агнуур зэрэг олон шалтгааны улмаас тарвага устаад байсан юм. Тиймээс Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын мэргэжилтнүүд талуудтай хамтран 2019 оноос 2024 оны эцэс гэхэд 250 тарвага (*Marmota sibirica*)-г Хустайн нурууны БЦГ-аас авч ирж, сэргээн нутагшуулсан.



2019 оноос МУИС-тай хамтран эко клубийн сурагчдыг шинжлэх ухааны суурь судалгаатай танилцуулах зорилгоор “Залуу судлаачид” зуны сургалтыг Хар ямаатын байгалийн нөөц газарт хэрэгжүүлж байна. 2023 оны сургалтад зүүн аймгуудын 27 сурагчаас гадна Хятадын Шанхай хотын ахлах сургуулийн 4 сурагч, 2024 онд 45 хүүхэд тус тус хамрагдлаа. Хүүхдүүд ургамлын төрөл зүйлийг тодорхойлох, ховор болон аюулд өртөж байгаа төрөл зүйлийг үнэлэх, бэлчээрийн даац тодорхойлох үндсэн арга техникт суралцсан.

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТТАЙ ГАЗАР



Орон нутгийн хамгаалалтад авсан Ховд аймгийн Дөргөн сумын 32,244 га газрыг өргөтгөн 91,114 га болгож, мөн Увс аймгийн Завхан сумын 169,984 га газрыг Байгалийн нөөц газарт оруулахыг 2 сумдын болон аймгуудийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар дэмжсэн тогтоол гаргав. Ингэснээр Ховд, Увс аймгийн хэмжээнд Монгол бөхөнгийн тархац нутгийн төгсгөл болох хойд хэсгийн нийт 261,098 га газрыг “Бөхөн А” болон “Бөхөн Б” нэршлээр улсын тусгай хамгаалалтад оруулах ажил явагдаж байна.



Гол мөрний урсац бүрэлдэх эхийн хамгааллыг нэмэгдүүлэх зорилгоор:

- Увс нуур-Тэсийн голын сав газарт хамаарах Тэс голын тусгай хамгаалалттай газар нутгийн өргөтгөлөөр 8,714 га газар,
- Хүйсийн говь-Цэцэг нуурын сав газарт хамаарах Говь-Алтай аймгийн Тонхил суманд 288 га газар,
- Хяргас нуур-Завхан голын сав газарт хамаарах Завхан аймгийн Богд, Чигэртэй голын эхийн 113,000 га газар,
- Хэрлэн голын сав газарт хамаарах Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутаг Тэнүүн, Барх голуудын эхийн 119,719 га газар нутгийг тус тус орон нутгийн тусгай хамгаалалтад авах шийдвэрийг тухайн сумдын ИТХ баталжээ.



© Б.Гангулга / Дрлийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

ХИЛИЙН НОГООН БҮС



“Хилийн ногоон бүс” санаачилгын хүрээнд Хил хамгаалах ерөнхий газрын хил хамгаалалтын нэгдсэн систем бүтээж, “Саран-2008” программыг шинэчлэн хөгжүүлэх ажилд дэмжлэг үзүүлснээр, улсын хил, хилийн зурвас, бүс нутаг дэвсгэр дэх зэрлэг амьтдын тоо толгой, байршил нутаг, шилжилт хөдөлгөөнийг тогтмол хянаж, мэдээллийн сан үүсгэн хадгалах боломжтой болов. Мөн энэ цахим программыг интернэтгүй орчинд ашиглах бүрэн боломжтой байдлаар газар зүйн мэдээллийн системийн технологиудад суурилуулан хөгжүүлсэн.



Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар зэрлэг амьтдын шилжилт хөдөлгөөний ажиглалт, мониторинг хийх, төрөл бүрийн судалгааны ажлынхаа үр дүнг баталгаажуулах зорилгоор зарим онцлог газруудад автомат ажиллагаатай 10 алсын зайн камеруудыг 2021 оноос төрийн байгууллагуудтай хамтран байршуулсан. Эдгээр камерийн тусламжтайгаар 2023 онд Увс аймгийн Сагил сумын нутагт хил дамнан орж ирсэн түймрийг илрүүлж, шуурхай арга хэмжээ авч унтраасан байна. Түймрийг 30 гаруй хүнтэй бүрэлдэхүүн 6 цагийн турш ажиллаж, ховор ургамлууд, айлын өвөлжөө хашаа бууц, бэлчээр, хил орчмын байгууламжууд шатаж, зэрлэг амьтан эндэж, дайжихаас урьдчилан сэргийлж чаджээ. Камер байршуулсан санаачлагыг өргөжүүлэн Хил хамгаалах байгууллага болон нутгийн иргэд, сумын зүгээс санхүүжилт гарган 2024 онд энэ бүс нутагт нэмж 5 алсын зайн камер суурилуулсныг өдгөө хил хамгаалах болон байгаль хамгаалах үйлсэд ашиглаж байна.



Увс аймаг дахь Хилийн цэргийн ангитай хамтран “Хилийн ногоон бүс” санаачилгын хүрээнд Бөхмөрөн, Сагил, Давст, Түргэн сумдын хилийн зурвас бүсэд нутаглаж буй ард иргэд, малчдад хууль бусаар амьтан агнах, байгалийн ургамал түүж, бэлтгэх, хил орчмын дэглэмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ухуулга сурталчилгааны ажлыг нийт 300 гаруй хүнд хүргэж хийснээс гадна, тэдгээр сумдын хилийн зурваст нэвтрэх төв зам дагуу ухуулга, сурталчилгааны самбаруудыг байршуулав.



8000



Баян-Өлгий, Говь-Алтай аймаг дахь Хилийн цэргийн дугаар ангиуд 8,000 гаруй нутгийн иргэдэд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Амьтны тухай, Ойн тухай, Байгалийн ургамлын тухай хуулиуд болон хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, ялангуяа хууль бусаар ан агнах, худалдаалах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулж, сурталчилгааны материалуудыг тараасан байна.

20



Монгол Алтайн нурууны байгалийн цогцолборт газар гадаад, дотоодын аялагч нарт хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хил орчмын дэглэмийг сахиулах зорилгоор хилийн ногоон бүсийн анхааруулах 20 самбар, хууль сурталчлах 4 ширхэг том самбарыг байршуулж, алсын зайн камерын систем тавьж, бүрэн хяналттай болгов.



Хил дамнасан аргаль хонины хяналтын хөтөлбөрийг 2018 онд Монгол Улс болон ОХУ-ын засгийн газраас албан ёсоор баталж, түүнээс хойш хоёр жил тутамд тооллогыг зохион байгуулж ирсэн. 2007 онд 638 толгой байсан бол Хилийн цэрэг, Увс нуурын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, нутгийн иргэдийн байгаль хамгаалах үйлсийн үр дүнд хилийн дагуух аргаль хонины тоо толгой 2023 онд 4024 болж өсчээ.



© М.Ууганбаяр / Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

ГАЗРЫН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТ

© Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН НЭГДСЭН ТӨЛӨВЛӨЛТ



Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Хэнтий аймгийн Баян-Адарга, Баян-Овоо, Норовлин, Дорнод аймгийн Булган, Матад, Хөлөнбуйр, Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Сүхбаатар, Мөнххаан сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг талуудын оролцоотойгоор боловсруулан 2023 онд холбогдох аймаг, сумдын ИТХ баталсан. Газар зохион байгуулалтын төлөвлөлт хийхдээ уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтол, биологийн олон янз байдал буюу цагаан зээрийн холбоос нутаг, цэн тогорууны чухал амьдрах орчныг харгалзан, түүнчлэн хууль эрх зүйн орчны хүрээнд зайлшгүй уялдах шаардлага бүхий тусгай хамгаалалттай газар нутаг, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс зэргийг уялдуулан шинэлэг аргазүйгээр боловсруулсан нь зүүн бүсийн хэмжээнд байгаль орчны асуудлыг тусгасан газрын нэгдмэл түвшний төлөвлөгөө болсоноороо онцлог байв.



Талуудын оролцоог ханган, тэдний ашиг сонирхлыг нэгтгэсэн нэгдмэл төлөвлөгөө боловсруулахын тулд ажлын хэсэг байгуулан ажиллаа. Энэ хүрээнд 110 гаруй удаагийн ажлын хэсгийн болон бусад талуудын оролцоотой уулзалт, хэлэлцүүлгээр нийт 11,173 (47% эрэгтэй, 53% эмэгтэй) иргэд саналаа өгч, газрыг тогтвортой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх шийдлийг хамтдаа хэлэлцэж, төлөвлөгөөндөө тусгалаа. Төлөвлөгөөг боловсруулах явцад гарсан амжилт, сургамж, шинэлэг санаачилгыг төрийн болон төрийн бус байгууллага, судалгааны хүрээлэн, их, дээд сургууль, хувийн хэвшлийн төлөөлөл бүхий талуудаар хэлэлцүүлэн “Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний аргачлал” болон “Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний аргачлал”-д уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтол, биологийн олон байдлыг харгалзах нэмэлт өөрчлөлтийг тусган сайжруулан боловсруулав. Энэ арга зүй нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А/304, А/305 тоот тушаалаар баталсан ба цаашид улсын хэмжээнд албан ёсоор ашиглагдах юм.



Газрын нэгдмэл удирдлагын цахим системд бүх шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хянах зорилго бүхий “Газар зохион байгуулалтын төлөвлөлтийн статистик”, газар зохион байгуулалтын төлөвлөгөөг боловсруулахдаа экосистем, зэрлэг амьтдын тархац нутаг, чухал амьдрах орчин, холбоос нутгийг харгалзахад дэмжлэг болгох “Биологийн олон янз байдлын статистик” талбаруудыг тус тус хөгжүүлээд байна.

УУР АМЬСГАЛД ДАСАН ЗОХИЦСОН ГАЗАР ТАРИАЛАН



Нөхөн сэргээх газар тариалангийн нэг хэсэг болох холимог тариалан нь олон төрлийн таримлыг нэг талбайд тарьж хөрсний үржил шим болон микро биетийн зөв харьцааг үүсгэн, химийн гаралтай хоруу чанар өндөртэй бодис ашиглалгүй үр тариа ургуулдаг технологи ба энэ нь олон талт эрсдлийг бууруулдаг ач холбогдолтой. 2022 оноос “Хэнтийн тариалан” ХХК-тай хамтран холимог тариалангийн сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор залуу тариаланчдад зориулсан Менторшип хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж, өнөөдрийн байдлаар зүүн бүсийн хэмжээнд 12 аж ахуйн нэгжийн 4,272 га талбайд нэвтрүүлээд байна:

- 10 ААН 1612 га талбайд 4 таримлын холимог (улаанбуудай ба маалинга, вандуй ба шар гич, гурвалжин будаа ба маалинга, овъёос ба улаанбуудай).
- 4272 га талбайд 7 таримлын холимог (улаан буудай ба маалинга, улаан буудай ба овъёос, судан, маалинга ба вандуй, вандуй ба шар гич, арвай ба маалинга, шар будаа ба гурвалжин будаа, хөх тариа маалинга)
- Шар гич ба вандуй холимог тариалалтын үр дүн: Хог ургамал ургаагүй, ургац улсын дунджаас 2 дахин их, хөрсний агрегатлаг бүтэц, мөөгөнцрийн агууламж сайжирч улаан буудайн моно тариалантай харьцуулахад хөрсний нягт эрс багасч, хөрсний хачиг болон баграда цохны тархалт 2022 онтой харьцуулахад эрс буурсан.



Ногоон тэжээлийн тариаланг 4 аж ахуй нэгж судан өвс 150 га, овъёос 360 га талбайд тариалсаны үр дүнд нийт 1,444 тонн ургац хураалаа.



2024 оноос бүрхүүл тариаланг нэвтрүүлж эхлээд байгаа ба 13 төрлийн таримлын холимог (50 га) болон өвөлжих хөх тариа (80 га)-г тарьж туршиж байна. Энэ нь намар, хаврын улиралд хөрсөнд дулаан хуримтлуулах, хөрсөө тэжээх, хөл ургамлыг дарангуйлах, хар уриншийг халах, химийн бодисын хэрэглээ бууруулах гэх мэт ач холбогдолтой.

284 га



Малчид, тариаланчдын зөрчлийг бууруулах, тариаланд нэвтрүүлж буй технологи, арга аргачлалын үр нөлөөг сайжруулах зорилгоор тариалангийн талбайг хашаажуулах нь нийтлэг байдаг ч ихэнхдээ өргөст тор ашигладаг нь ялангуяа нүүдлийн зүйл болох цагаан зээрийн хувьд үхэл хорогдолд нөлөөлөх эрсдлийг үүсгэж байгаа билээ. Тиймээс зэрлэг амьтанд ээлтэй байх шаардлагыг хангасан буюу өргөст торноос татгалзсан загварыг санал болгон 284 га тариалангийн талбайг хашаажуулахад дэмжлэг үзүүлэн хамтран ажилласан. Түүнчлэн энэ талбайд элдэншүүлэггүй технологи нэвтрүүлэн, элит сортын үрээр үржүүлж, сэлгээний шинэ таримал, ногоон тэжээл тарьж эхэлсэн бөгөөд хөрсийг элэгдэл эвдрэлээс хамгаалах, улмаар тогтвортой ургац хураан хувь нэмэр оруулж байна.



© М.Ууганбаяр / Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

БЭЛЧЭЭРИЙН НЭГДСЭН МЕНЕЖМЕНТ

12000



Монгол орны бэлчээрийн даац 70 орчим хувиар хэтэрсэн хэмээн эрдэмтэн, судлаачид үздэг. Үүнийг малчид ч хүлээн зөвшөөрч нэг малаас авах ашиг шимээ нэмэгдүүлэх, бэлчээрийн даацад тохирсон мал маллах сонирхол нутгийн иргэдийн дунд түгээмэл болж байна. Энэ эрэлтийг харгалзан Увс аймгийн Бөхмөрөн суманд мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжийг байгуулснаар 2019 оноос хойш 198 өрх үйлчлүүлж нэг малаас авах ашиг шим нэмэгдэж (эм хонь 8 кг, хээлтүүлэгчийн амьдын жин 17 кг нэмэгдсэн) хонин сүргийн тоо 12000 толгойгоор цөөрч бэлчээрийн дарамт буурч байна.

616



Увс аймгийн Түргэн, Ховд сумд, Говь-Алтай аймгийн Дарив, Баян-Уул сумдын удирдлага, бэлчээрийн мэргэжилтнүүдэд зөвлөлдөх уулзалт, тусгай сургалт, мэргэжлийн зөвлөх үйлчилгээгээр байгальд ээлтэй бэлчээрийн менежментийн мэдлэг олгосноор бэлчээрийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувьд хүрлээ. Сумдын удирдлагууд 616 өрхөд бэлчээр ашиглах журмаа танилцуулж, малын бүтээгдэхүүнийг эргэлтэд оруулах талаар сургалт хийсний дүнд малын тоо дунджаар 15%, Баян-Уул сумынх 25%-иар буурлаа. Түргэн сумын удирдлага зэрлэг амьтдын үржлийн үед амьдрах орчныг нь чөлөөлөх захирамж гаргаж хэрэгжүүллээ.

21 ТОНН




Ирвэсийн тархац нутаг дахь сумдын 133 өрхийг тэжээлийн ургамал тарих сургалтад хамруулж үр тараасны дүнд 2023 оны намар 21 тонн ургац хурааж авсан нь бусад малчдыг тэжээлийн ургамал тарихад сэдэлжүүлж бэлчээрийн даац буурахад нөлөөллөө. Мөн 31 өрх хөл газрын ургамлаар шим тэжээлтэй ногоон дарш бэлтгэх аргачлалын сургалтад хамрагдаж нийт 500 кг даршийг 2023 оны намар бэлтгэн авсан.



Монгол орны зүүн 3 аймгийн 9 сум 1,168,178.9 га доройтсон газрыг нөхөн сэргээхээр газрын менежментийн төлөвлөгөөндөө тусгасан нь өмнөх жилүүдийнхээс эрс нэмэгдсэн үзүүлэлт байна. 2023 оны 5-8 сард 5 сум 82000 га бэлчээрийг ашиглалтаас чөлөөлсөн нь орон нутгийн удирдлага бэлчээр ашиглалтаас малчидтайгаа хамтран төлөвлөж, хэрэгжүүлэх нь үр дүнтэйг харууллаа.



Дорнод аймгийн Хөлөнбуйр сумын удирдлагын багийн манлайлал, багийн дарга, малчдын идэвхтэй оролцоотойгоор бэлчээр ашиглалтын журмаа амьтдын нүүдэл, шувуудын амьдрах орчныг харгалзан шинэчиллээ. Шинэ журам 2023 оны 7-р сард орон нутгийн хурлаар дэмжигдэж, Хууль зүйн яамаар батлууллаа.



НУТГИЙН ИРГЭД БАЙГАЛЬ ХАМГААЛАЛД

© НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага (FAO) / Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар





Алтай-Соёны экобүс дэх “Ихэс нуурын хишиг” хадгаламж зээлийн хоршооны 12 гишүүд хоршооноос авсан зээлээрээ хөрөнгө оруулалт хийж орон нутагтаа гэр бүлийн бизнес хөгжүүлж сарын орлого 200-500 мянган төгрөгт хүрчээ. Малчдын хоршоонд итгэх итгэл нэмэгдэж, урт хугацаанд тасралтгүйгээр орлогоо нэмэгдүүлэхийн давуу талыг ойлгосон. 2018 онд эхэлсэн 12 хоршоодын нийт хөрөнгө бараг 4 тэрбумд хүрчээ.



8

Алтай-Соёны бүсийн 8 хөдөө аж ахуйн хоршооны 1000 гаруй гишүүд сүүлийн 4 жилд үнийн зөрүүгээс 98 сая төгрөг, ноогдол ашиг 32 сая төгрөгийг гишүүддээ хуваарилсан. Говь-Алтай аймгийн Баян-Уул сумын “Санжин Богд” хоршоо хөтөлбөрийн газрын дэмжлэгээр түүхий эд цуглуулах агуулахаа өргөтгөсний үр дүнд агуулах барихаас өмнө түүхий эдийн үнийн зөрүүгээс 1.2 сая төгрөг хуваарилж байсан бол 2023 онд хоёр дахин нэмэгдэж 2.5 сая болжээ.

107 сая



Увс, Говь-Алтай аймгийн 8 хоршоо жижиг үйлдвэрийн бизнесээс олох орлого 2023 онд 31,8 хувиар өсөж 107 сая төгрөгт хүрснээс үзэхэд малчид малын түүхий эдээр бүтээгдэхүүн үйлдвэрлэж зах зээлд нийлүүлэх боломжтой байна.



46 сая



Монгол орны зүүн бүсийн малчдын санхүүгийн боловсролыг дээшлүүлэх сургалт, туршлага хуваалцах уулзалтуудад хамрагдсан малчид санаачилгаараа “Ашид ундран арвижих”, “Адарга баян дүүрлиг” зэрэг хадгаламж зээлийн хоршоо байгуулж, 2023 оны эцсээр 151 гишүүнтэй, 40 сая төгрөгийн дундын өмч, 40 сая төгрөгийн хадгаламж, 46 саяын зээл олголттой болжээ.

7.3 тн



Хэнтий аймгийн Баян-Овоо сумын 14 өрхөөс эхэлсэн “Эко гудамж” санаачилгад тус сумаас гадна Норовлин сумын олон өрх нэгдэж, техникийн сургалт, зөвлөгөө авч ажилласны дүнд 2023 онд өрхүүд 4.7 га-аас 13 төрлийн 10.1 тонн хүнсний ногоо, хураасны 7.3 тонныг хүлэмжээс авсан ба тэд өрхийн хүнсний хэрэглээгээ хангаад зогсохгүй зах зээлд нийлүүлэх боломж ийнхүү бүрдлээ.

500



Байгаль хамгаалалд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Шийдлийг хамтдаа эрэлхийлье” уулзалтыг жил бүр 500 гаруй эмэгтэйчүүдийн оролцоотойгоор зохион байгуулж байна. 2023-2024 онд баруун бүсийн аймгуудын байгалийн нөөц ашигласны төлбөр (БНАТ)-ийн зарцуулалтыг хуулийн заалттай нийлүүлэх, нөөцийн ашиглалтыг сайжруулах, үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажилласны үр дүнд огт байхгүй байсан Баян-Өлгий аймаг хамгийн өндөр буюу 70 гаруй хувийн зарцуулалттай, бусад аймгууд ч бүрдүүлэлт, зарцуулалтын хувь хэмжээ нь 20 хувиар нэмэгдсэн бол энэ жилээс БНАТ орлогын зарцуулалтын үр дүнд анхаарах цаг нь болсон талаар нэгдсэн ойлголтод хүрлээ.





© Б.Гангулга / Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

МЭДЭЭЛЭЛ ХАРИЛЦАА



* Хүүхдийн зураг зургийг эцэс эх, асран хамгаалагчаас зөвшөөрөл авсан болно.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар нь 1997 оноос эхлэн Хүүхдийн танин мэдэхүй, байгаль орчны боловсролыг дэмжин ажиллаж байгаа бөгөөд 2023-2024 онд дараах санаачлагуудыг хэрэгжүүлж байна:



“Миний нутгийн дэгдээхэй”, “Мойлхон чамд баярлалаа”, “Бөхөн хамгаалагчтай нэг өдөр” зэрэг санаачилга нь хүүхдэд амьтдыг танин мэдэх, хамгаалах үйлсэд сайн дураараа оролцох боломжийг олгож байна.



Танин мэдэхүй, шинэлэх ухааны ойлголт өгөх зорилгоор МУИС-тай хамтран Хар ямаатын БНГ-т “Судлаач сурагч”, Онон-Балжийн БЦГ-ын захиргаатай “Өсвөрийн байгаль хамгаалагчид”, Ховд Их сургуультай хамтран “Сайр хайрханы хүүхдүүд” зэрэг хөтөлбөрийг тус тус хэрэгжүүлж байна. Эдгээр хөтөлбөрөөр мөнх цасны хайлалтын мониторинг, ургамлын судалгаа, зэрлэг амьтдын талаарх анхан шатны судалгаа зэрэг олон талын мэдлэгийг олж авч байна.



Уламжлал ёсоор жил бүр Цоохор ирвэсийг хамгаалах өдөр, Монгол бөхөнгийн өдөр, Цагаан зээрийн өдөр, Булгийн өдөр, Тул загасны өдөрлөг, Тогоруу шувуудаа үдье, Эх дэлхийн цаг зэрэг байгаль орчны



* Хүүхдийн зураг ашиглахдаа эцэх эх, асран хамгаалагчдаас зөвшөөрөл авсан болно.

© Т.Доржханд / Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

тэмдэглэлт өдрүүд, олон нийтийн арга хэмжээг тодорхой сэдвийн хүрээнд хүүхэд, нутгийн иргэдтэй хамтран тэмдэглэн өнгөрүүлсэн.



Ирээдүйн байгаль хамгаалагчдыг бэлдэх, хүн-зэрлэг амьтан хоорондын зөрчлийг бууруулж, зэрэгцэн орших сэдэл ухамсар төлөвшүүлэх зорилгоор 4, 6-р ангийн хичээлийн хөтөлбөрт ирвэс түүний байгальд гүйцэтгэх үүргийн талаар иж бүрэн, идэвхтэй сургалтын хөтөлбөр боловсруулж гарын авлагыг баруун, өмнөд бүсийн бүх сургуульд хүртээмжтэй тараалаа. 2024 оны 4 сард 54 багшид хөтөлбөр хэрэгжүүлэх онлайн сургалт өгч Увс аймгийн 750, Говь-Алтай аймгийн 600 сурагч хамрагдлаа.



Шинээр байгаль хамгаалах эко-клубын гишүүн болж буй сурагчдад багаар ажиллах арга, зохион байгуулалт, хамтран шийдвэр гарах зэрэгт дэмжлэг болгож “Байгаль хамгаалах сурагчдын гарын авлага”-ыг хэвлэн түгээлээ. Энэхүү гарын авлага нь дан ганц бидэнтэй холбоотой ажилладаг хүүхдүүдээр зогсохгүй энэ чиглэлээр ажиллах сонирхолтой олон хүүхдүүдэд түгээж байгаа нь тэдний ирээдүйд хамтарч ажиллах олон сайхан боломжид бага ч атугай дэмжлэг үзүүлнэ гэдэгт найдаж байна.



“Говийн гайхамшигт-6” санаачилгын хүрээнд талуудын уулзалтыг анх 2016 онд ГИДЦГ-ын “Б” хэсгийн Хамгаалалтын захиргааг түшиглэн зохион байгуулж “Тахийн талын тунхаг бичиг” гаргаснаас хойш 8 жилийн хугацаа өнгөрчээ. 2023 онд энэхүү уулзалт хэлэлцүүлгээр орон нутгийн манлайлыг дэмжих зорилгоор Говь-Алтай аймгийн Байгаль орчны газарт санаачлагыг цааш авч явуулахаар хүлээлгэн өгсөн. 2024 оны 8 дахь хэлэлцүүлэгт Говь-Алтай аймгийн Байгаль орчны газар “Говийн гайхамшигт-6 амьтны амьдрах орчин ба усан хангамж” сэдвийн хүрээнд 90 гаруй эрдэмтэн судлаачид, ТХГ, аймгуудын Байгаль орчны газар, бусад олон улсын байгууллагуудын төлөөллийг оролцууллаа. Энэ удаагийн хурлаар зэрлэг амьтдын талаар хийгдсэн судалгааны ажлын үр дүн, хамгааллын чиглэлээр гарсан зөвлөмжүүдийг сонсож зургаан амьтны амьдрах орчныг цогцоор нь хамгаалах 5 жилийн төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийг томиллоо.



Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын хамт олон “Монгол бөхөн” хэмээх шинжлэх ухааны хялбаршуулсан баримтат киног бүтээж олны хүртээл болголоо. 16 минут үргэлжлэх энэ кинонд Монгол бөхөнгийн зан төрх, идэш тэжээлийн онцлог, дөрвөн улирлын амьдралыг сонирхолтой дүрслэлээр харуулсан юм. Кинонд Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын ажилтнуудын 5 жилийн турш авсан дүрсийг ашиглаж хийлээ. Түүнчлэн “Монгол бөхөнгийн зан төрх” зурагт номыг олны хүртээл болголоо. Бөхөнгийн биологи, экологи, зан төрхийн талаар сонирхолтой мэдээллийг энэхүү зурагт номоор дамжуулж уншигч олонд хүргэлээ.



Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Байгалиа хамгаалъя” кампанит ажлыг Экологийн цагдаагийн албатай хамтран жил бүр зохион байгуулж байна. 2024 онд 13 видео контент, 15 ярилцлага, онлайн мэдээний сувгуудаар 10 мэдээ, нийтийн сүлжээгээр 26 зурагт хуудас, 114 бусад пост, контент, мэдээ цацагдлаа. Давхардсан тоогоор 21,6 сая хүнд хүрч, 8588 санал иржээ.



МУИС-тай хамтран “Судлаач оюутан” эрдэм шинжилгээний хурлыг 7 дахь жилдээ амжилттай зохион байгуулсанаар МУИС, ХААИС, МУБИС зэрэг их, дээд сургуулийн магистрын болон бакалаврын түвшний оюутан судалгааны үр дүнгээ танилцуулах талбар болон өргөжжээ. Эрдэм шинжилгээний хуралд оролцсон хоёр оюутан судалгааны өгүүллээ олон улсын шинжлэх ухааны сэтгүүлд илгээжээ.

60+

Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд хувь хүний ойлголт, оролцоог нэмэгдүүлэх зорилготой “Эх дэлхийн цаг” арга хэмжээг Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар 14 дэх жилдээ тэмдэглэлээ. 2024 оны арга хэмжээг “Говийн гайхамшигт 6” санаачилгын хүрээнд говийн амьтдын ундаалдаг булаг, уст цэг болох Ховд аймгийн нутаг дахь хоёр булгийн эхийг хашихад шаардлагатай санжүүжилтийг босгох хандивын аян зохион байгуулж 1.8 сая төгрөг (590 USD) цугларлаа. Энэ нь хэдийгээр бага мөнгө мэт санагдаж болох ч иргэдийн сайн дурын санаачилгын эхлэл гэдгээрээ чухал ач холбогдолтой юм.



© Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар



40

Монгол улсын хүн амын ойролцоогоор 50% амьдардаг Улаанбаатар хотын иргэдэд цоохор ирвэс хамгаалалын талаар мэдээлэл өгөх зорилгоор 2023 онд Монголын урчуудын эвлэл, Байгалийн түүхийн музейтэй хамтран 53 урлаачийн 40 бүтээлээр үзэсгэлэн гаргаж, виртуалаар үзэх боломжийг олгосноор 1000 орчим хүнд биетээр болон онлайнаар хүрлээ. 2024 онд МУИС-ийн Экологийн боловсролын төв дээр “Уулсын хаан цоохор ирвэс” танин мэдэхүйн интерактив үзмэр нээлээ. Түүнчлэн Монгол улсдаа анх удаа гэж хэлж болох ирвэсийн 3D видео бүтээж ШангриЛа моллын дэлгэцээр олон нийтэд дэлгэсэн нь дан ганц Монгол хүмүүсийн харааг булаагаад зогссонгүй сүлжээний байгууллагуудын сайшаалыг хүртлээ.



40

Монгол орны цоохор ирвэсийн амьдралын тухай өгүүлсэн, зэрлэг амьтны гэрэл зурагчдын авсан 40 зураг бүхий “Уулын эзэн” явуулын гэрэл зургийн үзэсгэлэн Алтай-Соёны бүс нутгаар 14.000 км аялж, 9100 гаруй сурагч багачууд, 1800 гаруй нутгийн иргэдэд хүрлээ. Үзэгчдийн 60 гаруй хувь нь анх удаа ийм үзэсгэлэн үзсэндээ сэтгэгдэл өндөр байлаа.



8

МҮОНРТ-тэй хамтран тус байгууллагаас гаргасан хүүхдийн номоос сэдэвчлэн сонсдог ном бэлтгэн олон нийтийн сүлжээнд байршуулав. Уг аудио номууд нь зурагт үзэх, интернэт ашиглах боломжгүй харааны бэрхшээлтэй хүүхдүүд болон сургуулийн өмнөх бага насны

хүүхдүүдэд зориулагдсан. Мөн уламжлалт аргаар ноосыг эсгийжүүлж цоохор ирвэс, монгол бөхөн, тогоруу, хойлог зэрэг амьтдыг танин мэдэх зорилгоор 8 цуврал хүүхэлдэйн кино хийсэн нь олон хүний талархлыг хүлээлээ.



Бага насны хүүхэд багачуудад зориулж “Хөөрхөн Бөхөндэй миний хөгжилтэй найзууд” 3 цуврал, “Тулын хүү Тулбага” үлгэрийн ном болон “Зээрийн янзага” комик ном гаргалаа.



Монголын хүүхэлдэйн театртэй хамтран “Хөөрхөн Бөхөндэй миний хөгжилтэй найзууд” номын зохиолоор 5 цуврал хүүхэлдэйн жүжиг бэлдэж, дүрсжүүлэн олны хүртэл болголоо. Ингэхдээ сонсголын бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулж дохионы хэлийг оруулж өгсөн нь мэдээллийг тэгш, хүртээмжтэй хүргэхэд чухал гэж үзсэн болно.

5.4 сая




Хоёр жилийн хугацаанд байгууллагын цахим сурталчилгаа, мэдээллийг 5.4 сая хүн үзэж, 538,000 хандалт авч, дагагчдын тоо 22,000 хүнээр нэмэгдсэн. Түүнчлэн 107,513 хүнийг мэдээлэл сурталчилгааны ажилд оролцууллаа. 2024 оны байдлаар бид 7 аймгийн хэмжээнд сайн дурын 52 байгаль хамгаалах сурагчдын эко-клубын 1642 гишүүн хүүхдүүдтэй хамтран ажиллаж байна.



© Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

ЗАСАГЛАЛ, САНХҮҮЖИЛТ






Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар нь Ази Номхон далайн бүсийн төвд хамаардаг. Манай байгууллага нь Байгаль хамгаалал, мэдээлэл харилцааны нэгж болон Санхүү, захиргааны нэгж гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэх ба Алтай-Соён эко бүс болон Амар мөрний хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутагт хариуцан зохион байгуулах үүрэг бүхий хоёр салбар оффистой. Төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг Байгууллагын захирал, Байгаль хамгааллын захирал, Санхүү, захиргааны захирал гэсэн бүрэлдэхүүнтэй Удирдлагын менежментийн баг гаргадаг.

Нийт 51 ажилтантай бөгөөд Улаанбаатар хотод 27 (52,94%), орон нутагт 24 (47,6%) хүн ажиллаж байна. Ажилтнуудын 45% нь эмэгтэй, 55% нь эрэгтэй бөгөөд хамгийн удаан нь 22 жил ажиллаж байна.

Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гаас байгаль хамгааллын ажлыг далай тэнгис, цэнгэг ус, биологийн олон янз байдал, ой, уур амьсгал ба эрчим хүч, хүнс, санхүүгийн систем гэсэн 7 практик зорилт тавин үйл ажиллагаагаа нэгтгэн, нэгдсэн хүчээр ажиллаж байна. Манай байгууллагын хувьд далай тэнгисээс бусад практик зорилтуудад хувь нэмрээ оруулан ажиллаж, 2023 онд 2,8 сая ам.доллар, 2024 онд 3 сая ам.долларыг байгаль хамгаалах ажилд зарцуулжээ (график 1).

НИЙТ ТӨСӨВ (ам.доллар)



Ингэхдээ бид Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн төв байгууллага, Нидерланд, Герман, Польш, Швецарь, АНУ, Япон, Франц болон АНУ-ын Дэлхийн байгаль хамгаалах сан, АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID), Даян дэлхийн байгаль орчны сан (GEF), Дэ Нэйче Консерванси (TNC) болон Өвлөгдөн үлдэх газар нутаг сан (LLF) зэрэг байгууллага, хамтын ажиллагааны түншлэлийн үр дүнд төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллаа.





© Б.Гангулга / Дрлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар

БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ ХАМГААЛАЛ



Бид байгаль орчин, нийгэм хамгааллын 6 үндсэн стандартыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг бөгөөд хүний эрхийг хүндлэх, нутгийн иргэдийн эрх ашгийг харгалзах, жендерийн тэгш оролцоог хангах гурван зарчмыг баримталж байна.

Бидний зорилго, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчин болон нутгийн иргэдэд эрсдэл учруулах эсэхийг тодорхойлж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, шаардлагатай бол сааруулах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлдэг юм. Түүнчлэн зохион байгуулж буй үйл ажиллагаанд хамрагдах хүүхэд бүрийн аюулгүй байдлыг хангах “Хүүхэд хамгааллын журам”-тай бөгөөд тус журамд дурдсанаар хүүхдийн зураг авах, нийтлэх мөн арга хэмжээнд хамруулахаас өмнө эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг заавал авах, албадан хөдөлмөр эрхлэхээс сэргийлэх тухай зохицуулалтууд бий.



Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн байгаль орчин, нийгэм хамгааллын стандартуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг манай байгууллагын цахим хуудаснаас авна уу.



mongolia.panda.org



© Д.Ганбаатар / Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар



Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) нь иргэдээс өргөдөл, гомдол хүлээн авах, барагдуулах журамтай. Өргөдөл, гомдол гаргах боломжийн талаар мэдээлэл авахыг хүсвэл манай байгууллагын цахим хуудаст хандах эсвэл оффис дээр биечлэн ирэх, мөн манай байгууллагын **11-311659** утсанд хандах боломжтой.



© Д.Энх-Оргил / Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газар